



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 403

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Харилцаа холбооны зохицуулах хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглаж болох нийт 4 нэрийн 420,497,893.71 (дөрвөн зуун хорин сая дөрвөн зуун ерэн долоон мянга найман зуун ерэн гурван төгрөг далан нэгэн мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу ашиглах хугацааг сунгаж, үнийг нийт 100,892,148.95 (нэг зуун сая найман зуун ерэн хоёр мянга нэг зуун дөчин найман төгрөг ерэн таван мөнгө) төгрөгөөр шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга Г.Чинзоригт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

000717

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2020 оны 2 дугаар сарын 26 ны өдрийн
423 дугаар тогтоолын хавсралт



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ҮЛДЭХ ӨРТӨГГҮЙ,
АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАХ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Автомашины марк, улсын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл	Ашиглалтын хугацаа сунгах	Шинэчилсэн үнэ
			(төгрөг)	(жил)	(Төгрөг)
1	Соната NF, 10-62 УБЯ	2008/2008	25,178,589.00	1	4,196,431.50
2	Соната NF, 10-67 УНУ	2008/2008	26,713,134.42	1	4,452,189.07
3	Ландкрузер 200, 25-70 УБН	2012/2012	168,050,000.00	3	58,817,500.00
4	Ландкрузер 77, 49-89 УБЧ явуулын станцын машин	2007/2009	200,556,170.29	2	33,426,028.38
Нийт дүн			420,497,893.71		100,892,148.95
			(дөрвөн зуун хорин сая дөрвөн зуун ерэн долоон мянга найман зуун ерэн гурван төгрөг далан нэгэн мөнгө)	-	(нэг зуун сая найман зуун ерэн хоёр мянга нэг зуун дөчин найман төгрөг ерэн таван мөнгө)